

**“НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ
БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	№	Бодлогын зорилго, зорилт арга хэмжээ	Төсөв /сая төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн буюу гүйцэтгэлийн хувь	Тайлбар	Хариуцах байгууллага
			Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин				
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
1	5.5.2	Төрийн албан хаагчийг авлига, хээл хахууль авах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, түүнд			Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	2021	Авлигын эсрэг хуулийн дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажил биелсэн байна. Авлигын гэмт хэрэгт холбогдоо гүй болно.	2022	Авлига хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтыг 40 хувиар бууруулсан байна.	Тус газар нь Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны тусгайлан боловсруулсан төлөвлөгөөнд байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажил, сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд байгууллагын хүлээх үүрэгт хамаарах бусад ажлуудыг тусган хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 96,1 хувийн гүйцэтгэлтэй байгаа, авлигын зөрчил, гэмт хэрэг бүртгэгдээгүй болно. Мэдээллийн ил тод байдалд онцгойлон анхаарч ажилласан. Удирдлагын манлайлал, хүчин чармайлт, нийт албан хаагчдын идэвх оролцоо их байсан. Тухайлбал байгууллагын цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг жигд хангаж	100	-	ННЗБ

		хяналт тавьж ажиллах.								ажиллаа. Мөн байгууллагын мэдээллийн самбаруудыг сайжруулж, мэдээллийн багтаамж, олон нийтийн мэдээлэл авах сувгуудыг өргөжүүлэх зэрэг тодорхой ажлуудыг хийсэн. Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлсэн. Мөн Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээг тус газрын 25 албан хаагчтай гэрээг байгуулав. Авлигын эсрэг ном, гарын авлага, сурталчилгааны зурагт хуудас, бусад материалуудыг өгсөн бөгөөд дээрх гарын авлагуудыг тус газрын албан хаагчид болон харьяа байгууллагуудад тараан өгч Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан. Мөн сурталчилгааны зурагт хуудсыг мэдээллийг самбар болон албан хаагчдын өрөөнд нүдэнд харагдахуйц газар байршуулсан.			
--	--	-----------------------------	--	--	--	--	--	--	--	---	--	--	--

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

